

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний
өдрийн 145 дугаар тушаалын 9 дүгээр хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2019 оны 12 сарын 31

Байгууллагын нэр:

Говь-Алтай аймгийн Байгаль орчин,
аялал жуулчлалын газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Байгаль хамгаалагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Туслах түшмэл, ТЗ-2

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Сумын ЗДТГ

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийг хэрэгжүүлж, байгалийн нөөц баялгийг хариуцан хамгаалах, зүй зохистой ашиглуулах, нөхөн сэргээх, орчны бохирдлыг бууруулах, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын өмнө хариуцна.


Албан тушаалын зорилт:

1. Байгалийн нөөц баялагийг хамгаалах нөхөн сэргээх, зөрчлийг хянан илрүүлэх, таслан зогсоох, хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд гэм буруутай этгээдэд арга хэмжээ авч шийтгэл ногдуулах;
2. Байгаль орчны багц хууль, бодлого шийдвэрийг сурталчлах, байгаль хамгаалах уламжлалт ёс заншлыг түгээн дэлгэрүүлж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд оролцох идэвхи санаачлагыг өрнүүлэх;
3. Байгаль орчинд гарч буй өөрчлөлтийг ажиглаж, үнэлэлт дүгнэлт өгч, судалгаа шинжилгээ хийх;
4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.


Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Иргэн, аж ахуй нэгж, байгууллага байгаль орчны тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, таслан зогсоох;	Байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, хамгаалах, хамгааллын механизм бүрдсэн байна.	Г, Х Г, Х
	2. Байгаль орчны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуульд заагдсан эрх хэмжээний хүрээнд арга хэмжээ авах;		Г, Х
	3. Байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах;		Г, Х
	4. Биологи, түүх соёл, палеонтолги, геологийн хувьд ач холбогдол бүхий газруудыг онцлон хамгаалах;		Г, Х
	5. Байгалийн баялгийг нөхөн сэргээх болон биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;		Г, Х
	6. Хууль тогтоомжинд заасан тохиолдолд байгалийн нөөц баялгийг ашиглах эрхийн бичиг олгох;		Г, Х
	7. Иргэн, аж ахуй нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дагуу тухайн баялгийг ашиглах		Г, Х



	газрыг зааж өгөх, хяналт тавих;		
	8.Орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлэх.		Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хүн амд байгаль хамгаалах мэдлэг хүмүүжил олгох, үндэсний өв уламжлалыг эзэмшүүлэхэд туслах;	Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж, иргэдийн экологийн боловсрол нэмэгдсэн байна.	Г
	2.Байгаль орчны тухай хууль тогтоомжуудыг сурталчлан таниулах, хүрээлэн буй орчин, байгалийн нөөц ашиглах явцад гарч болох зөрчлөөс сэргийлэх ажлыг зохион байгуулах;		Г, Х
	3.Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх, зааж зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах;		Г,Х
	4.Орон нутгийн ард иргэдэд байгаль орчны талаарх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, гарын авлага, мэдээ, мэдээллээр хангаж ажиллах.		Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Байгаль орчны өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах;	Судалгааны иж бүрэн сантай болсон байна	Г
	2. Байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, биологийн төрөл зүйлийн ажиглалтын тэмдэглэл тогтмол хөтөлж, мэдээ цуглуулах, боловсруулалт хийх;		Г
	3. Байгалийн нөөц баялаг ашиглах үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах;		Г



	4. Судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх.		Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;	Дүрэм журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г
	2. Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;	Хэрэгжилт хангагдсан байна.	Г
	3. Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг гүйцэтгэж ажиллах, эргэн мэдээлэх;	Шуурхай хэрэгжүүлж, эргэн мэдээлсэн байна.	Г
	4. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээ, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар гарсан бодлого шийдвэр, хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллах;	Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажилласан байна.	Г
	5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэн ажиллах;	Хэрэгжилт хангагдсан байна.	Г
	6. Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Арга хэмжээ авч, тогтоосон хугацаанд тайлагнасан байна.	Г
III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	Байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй бол давуу тал болно.		
Мэргэшил	Бусад чиглэлийн мэргэжилтэй бол байгаль орчны чиглэлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий сургуулийн мэргэжлийн сургалтад хамрагдаж төгссөн байх		
Туршлага	-		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл	



		цуглуулах, боловсруулах харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.
	Асуудал шийдвэрлэх	- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх, хувилбарыг боловсруулах - бүтээлч санаачлагатай ажиллах, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих; - үл ойлголцолыг эв зүйгээр зохицуулах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид шударга байх; - хууль эрхзүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх, чадвартай байх;
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах - баг хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - байгууллагын зорилго, үйл ажиллагааг ойлгох, үр бүтээмжтэй ажиллах; - хамт олны эерэг нээлттэй, уур амьсгалыг дэмждэг байх; - харилцаа, зан байдлын доголдолгүй, өөрчлөлтийг хүлээж авах чадвартай байх.
	Бусад	- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; - мотоцикль, техник хэрэгсэлтэй харьцах; - газар нутгаа сайтар мэдэх; - шаардлагатай тохиолдолд биеэ хамгаалах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:


Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Байхгүй

Бусад харилцах субъект:

- сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны холбогдох албан тушаалтнууд;
- сумын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтнууд;
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн, албан хаагчид;
- тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаад;
- хууль, хяналтын байгууллагууд;
- төрийн бус байгуулага;
- хэвлэл, мэдээллийн байгууллагууд;
- олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр;
- иргэд.



V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Я.ЖАРГАЛЦЭЦЭГ*
2019 оны 12 дугаар сарын 31 ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 19...12 04

Дугаар: 336...

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2019.12.31

Дугаар: А/45

(тамга/тэмдэг)

ДАРГА

Д.БАТМАГНАЙ

Д:ОА0032 9016007

2019 оны 12 дугаар сарын 31 ны өдөр

